



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 07 өдөр

Дугаар 4469

Булган сум

“Өсвөрийн аврагч-2023” аймгийн аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1.1, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.3, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаал “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй ерөнхий боловсролын сургуулиудын ахлах ангийн сурагчдын дунд гамшгаас хамгаалах үйл ажиллагааны талаар мэдлэг олгох “Өсвөрийн аврагч-2023” тэмцээнийг 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдөр Булган суманд зохион байгуулсугай.

2.Тэмцээний удирдамжийг 1 дүгээр, үйл ажиллагааны зардлын төсвийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Тэмцээнд шаардагдах 2,195,000 (хоёр сая нэг зуун ерин таван мянга) төгрөгийг аймгийн Засаг нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Алтаншагай)-т зөвшөөрсүгэй.

4.Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ерөнхий боловсролын сургуулиудын өсвөрийн багийн бэлтгэл, бэлэн байдлыг хангаж тэмцээнд бүрэн оролцуулахыг Боловсрол, шинжлэх ухааны газар (Ж.Ганболд)-т үүрэг болгосугай.

5.Захирамжийн хэрэгжилтийг ханган биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Онцгой байдлын газрын дарга, хурандаа (Ш.Баасандорж)-д, хамтран зохион байгуулахыг Улаан загалмайн дунд шатны хорооны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Нямсүрэн), Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга (Ж.Ганболд), Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга (Б.Баярбат), олон нийтэд сурталчлан ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл, мэдээлэл олон нийттэй харилцах албаны дарга (Г.Алтанцэцэг)- нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

6333010457

Булган аймгийн Засаг даргын
2023 оны 06 дугаар сарын 7-ний өдрийн
А/969 дүгээр захирамжийн нэгдүгээр хавсралт



АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН НЭРЭМЖИТ “ӨСВӨРИЙН АВРАГЧ-2023” ТЭМЦЭЭНИЙ УДИРДАМЖ

Зорилго: Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдыг аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх, аврах, өөртөө болон бусдад анхны тусламж үзүүлэхэд сургаж дадлагажуулах, тэднийг тэсвэр хатуужил, авхаалж, самбааг сорих, хүнлэг энэргүй иргэн болгон төлөвшүүлэхэд оршино.

Нэг. Хамрах хүрээ

Зохион байгуулагч:

- Аймгийн Засаг даргын Тамгын газар
- Онцгой байдлын газар
- Улаан загалмайн хороо
- Боловсрол, шинжлэх ухааны газар
- Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар

Оролцогч:

-Булган аймгийн нийт Ерөнхий боловсролын сургууль, Мэргэжил, сургалт үйлдвэрлэлийн төвийн ахлах ангийн сурагчид, багш нар

Хоёр. Тэмцээн зохион байгуулах газар, хугацаа

2023 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 09:00 цагт Булган аймгийн Цогт Хун тайжын талбайд

Гурав. “Өсвөрийн аврагч” бүлгийн зохион байгуулалт, тавигдах шаардлага

Тэмцээнд оролцох “Өсвөрийн аврагч” бүлгийн /цаашид бүлэг гэх/ гишүүд нь ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчид байна.

Бүлэг нь ахлагч-1, гишүүд-6, нийт-7 сурагч, нэг чиглүүлэгч багштай байна. Бүлэгт 5 эрэгтэй, 2 эмэгтэй гишүүн байна.

Бүлгийн гишүүд 1-7 хүртэлх өөрсдийн хувийн дугаартай байна.

Чиглүүлэгч багш нь бүлгийн гишүүдийг тэмцээнд бэлтгэх, жигдрүүлэх ажлыг хариуцан зохион байгуулах бөгөөд тэмцээнд оролцохгүй.

Бүлгийн гишүүдэд доорхи чиглэлээр сургалт явуулсан байна. Үүнд:

-Гамшгаас хамгаалах тухай болон Галын аюулгүй байдлын тухай хуулийн зарлан мэдээлэл, бэлэн байдал, иргэний эрх, үүрэгтэй холбоотой зүйл, заалт болон “Бэлэн бай” сургалтын багц хичээл, үзэж судалсан байх.

-Аюулгүй амьдрах ухааны сургалтын хөтөлбөр”Өсвөрийн аврагч”бүлгийн сурагчдын гарын авлагыг уншиж, судалсан байх. /Тайлан, фото зургаар баталгаажуулах/

-Өөрийгөө болон бусдыг аврах, анхны тусламж үзүүлэх дадлага, сургалтад хамрагдсан байх. /Тайлан, фото зургаар баталгаажуулах/

-Жагсаалын бэлтгэл, үзүүлэх тоглолт хийж жигдэрсэн байх. /Тайлан, фото зургаар баталгаажуулах/

Дөрөв. Техникийн зөвлөгөөн

Техникийн зөвлөгөөнийг 2023 оны 06 дүгээр сарын 14-ны өдрийн 16:00 цагт Онцгой байдлын газрын Сургалтын танхимд болно. Техникийн зөвлөгөөнд чиглүүлэгч багш, бүлгийн ахлагч нар оролцоно.

Техникийн зөвлөгөөн дээр тэмцээний зохион байгуулалт, шалгаруулалтын талаар танилцуулга хийж, бүлгүүдийн төлөөлөл асуулт тавьж, саналаа хэлж оролцоно. Бүлгүүдийн тэмцээнд оролцох дарааллыг сугалаагаар тодруулна.

Техникийн зөвлөгөөнд ирэхдээ доорхи зүйлсийг бүрдүүлсэн байна.

- Сургуулийн захирлын баталсан бүлгийн мэдүүлэг
- Бүлгийн гишүүн бүрийн эмчийн дүгнэлтийн хуудас
- Өөрийн сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд аюулгүй амьдрах ухаан, бэлэн бай сургалт явуулж, нөлөөллийн ажлыг зохион байгуулсан талаар цаг, сэдвийн төлөвлөгөө, тайлан, зураг, бичлэгээр баталгаажуулсан материал.
- Бүлэг анхны тусламжийн иж бүрдэл бүхий цүнхтэй байна.
- Бүлэг тус бүр 40 см урт бариултай, 40х60 см хэмжээтэй, цагаан дэвсгэртэй хаягтай байх бөгөөд цэнхэр өнгөөр сум, сургуулийн нэр, дугаар, бүлгийн нэрийг бичсэн байна. Жишээ нь:

Булган аймгийн Тэшиг сумын
12 жилийн дунд сургууль
“Аврагч” өсвөрийн аврагч бүлэг

- Бүлэг бүр 5 см радиустай бэлэгдэл бүхий энгэрийн зүүлттэй байна. Энгэрийн зүүлтийг гишүүн бүр зүүн талын энгэртээ зүүсэн байна.
- Бүлгийн гишүүд хантааз, малгай, богино түрийтэй гутлаар жигдэрсэн байна.

Тав. Нээлтийн арга хэмжээ

Аймгийн Засаг даргын Тамгын газар, Онцгой байдлын газар, Улаан загалмайн дунд шатны хороо, Боловсрол, шинжлэх ухааны газар, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын төлөөллийг оролцуулан нээлтийн арга хэмжээг зохион байгуулна.

“Өсвөрийн аврагч” бүлгүүд тэмцээнд оролцох дарааллын дагуу жагсаж, ёслолын жагсаалаар алхана. Жагсаалын жигдрэлтийг хангах зорилгоор зохион байгуулагч талаас Онцгой байдлын газрын нэг салааг оролцуулж болно.

Тэмцээнийг нээж хүндэт зочид, зохион байгуулагчид үг хэлж, өсвөрийн аврагч бүлгүүдийн төлөөлөл өсвөрийн аврагчийн тангараг давуулж үг хэлнэ.

Зургаа. Тэмцээний үйл ажиллагаа

Жагсаалын үзлэг:

Жагсаалын үзлэгээр доорх зүйлсийг шалгана. Үүнд:

- Бүлгийн хаяг
- Бүлгийн гишүүн тухайн сургуулийн сурагч болохыг гэрчилсэн үнэмлэх /түүнтэй дүйцэх нотлох баримт/

- Төрсний гэрчилгээ
 - Хувцас жигдрэлт
 - Энгэрийн тэмдэг
 - Жагсаалын хувиргалт, жигдрэл, үзүүлэх тоглолтыг 8 минутад багтаана.
 - Бүлгийн ахлагчийн жагсаал командлах ажиллагаа
- Жагсаалын үзлэгээр шагналын 3 минут оноо өгнө.

Нэгдүгээр цэг: Мэдлэг сорих асуулт, хариулт

Гараанаас гарч 100м замыг туулан нэгдүгээр цэгт ирж, бүлгийн гишүүдийг жагсаан, бүлгийн дарга цэгийн шүүгчид “Эрхэм шүүгчид **“Аврагч”** бүлэг даалгавар гүйцэтгэхэд бэлэн” гэж илтгэнэ. /Бүлгийн ахлагч цэг бүрийн шүүгчид дээрхийн адил илтгэнэ/

Шүүгч урьдчилан бэлтгэсэн асуултаас 3 асуулт сугалуулна. Бүлгийн гишүүд 3 минутын хугацаанд бэлтгэж, хариулна. Цэгийн шүүгч зөв хариултыг танилцуулж, хариулт тус бүрийн оновчтой байдлыг харгалзан үзэж 0-3 минутын шагналын оноо өгнө.

Хоёрдугаар цэг: Усанд осолдогчийг аврах

Бүлэг нэгдүгээр цэгээс 100 метр замыг туулан хоёрдугаар цэгт ирнэ.

Тусгайлан бэлтгэсэн талбайд бүлгийн гишүүн бүр аврах цагаргийг 3 оноотой 3 байд шидэн усанд осолдогчийг аварна. Тусгай тогтоосон цэгээс 1 дэх бай 6м, 2 дахь бай 7м, 3 дахь бай 8м зайтай байна. Аврах цагираг олстой байна, олсыг аврах цагирагт наймын тоо ороох уяа зангилаа хийж уяна. /Хавсралт1/

- Цагаригийг 1 дэхь байд оруулбал 1 минутын шагнал
- Цагаригийг 2 дахь байд оруулбал 2 минутын шагнал
- Цагаригийг 3 дахь байд оруулбал 3 минутын шагналын оноо өгнө.
- Цагираг байд ороогүй тохиолдолд 0 оноо

Гуравдугаар цэг: Анхны тусламж

Бүлэг хоёрдугаар цэгээс гарч дугуйн саадыг туулж гуравдугаар цэгт ирнэ.

Амьсгал нь боогдсон нэг, хөнгөн гэмтэлтэй нэг, хүнд гэмтэлтэй нэг нэрвэгдэгчид анхны тусламж үзүүлнэ.

А. Амьсгал нь боогдсон нэрвэгдэгчийн амьсгалыг чөлөөлөх тусламжийг хиймэл хүн /муляж/ дээр үзүүлнэ.

Б. Хөнгөн гэмтэлтэй /Шалбарсан, зулгарсан, бага зэргийн цус алдалттай/ нэрвэгдэгчид боолт хийх тусламж үзүүлнэ.

В. Хүнд гэмтэлтэй /тулгуур яс хугарсан, нуруу нугасны гэмтэлтэй/ нэрвэгдэгчид анхны тусламж үзүүлж, дамнуурга ашиглан зөөвөрлөж, эмнэлгийн яаралтай тусламжийн хэсэгт хүлээлгэн өгнө.

Бүлгийн гишүүд хуваагдан нэрвэгдсэн иргэдэд нэгэн зэрэг анхны тусламж үзүүлж болох бөгөөд энэ нь бүлгийн багаар ажиллах чадвар, хамтын ажиллагааг харуулж өгнө.

Шүүгч бүлгийн гишүүдийн гар нийлэмжтэй ажиллагаа, даалгаврыг зөв гүйцэтгэсэн зэрэгт 0-3 минутын шагналын оноо өгнө.

Дөрөвдүгээр цэг: Хүч, авхаалж, самбаа сорих

Бүлэг гуравдугаар цэгээс гарч, торон саад болон самбарыг давж дөрөвдүгээр цэгт ирнэ.

Бүлгийн эрэгтэй гишүүд дүүжин савлуурт зургаа дарах, дүүжлэгдсэн байдлаас хөлөө өргөн савлуурт хүргэх, ес дарах цогцолбор дасгалыг гүйцэтгэнэ. Энэ хугацаанд багийн эмэгтэй гишүүд гарын доорх материал /сонин нийлэг уут/ ашиглан аяга, таваг хийх. Нэг цогцолбор дасгалыг зөв бүрэн гүйцэтгэсэн гишүүн бүрт 1 минутын шагналын оноо өгнө.

Бүлгийн бүх гишүүдын нийлбэрийг гаргаж багийн оноонд оруулна.

Тавдугаар цэг: Химийн хордолт

- Бүлэг дөрөвдүгээр цэгээс гарч 150 метр замыг туулан тавдугаар цэгт ирнэ.
 - Химийн хордолтын бүсэд амьсгал хамгаалах баг өмсөх бөгөөд шүүгчийн командаар 12 секундэд хамгаалах хэрэгсэл өмсөнө.
 - Хамгаалах хэрэгслийг 12 секундээс дээш хугацаанд өмссөн, алдаатай өмссөн багийн гишүүн бүрт 1 минутын торгууль ногдуулна.
 - Химийн аюултай бодис бүхий тэмдэг тэмдэглэгээ зааврыг хэрхэн тайлах дасгал хийх. /Тусгай бэлдсэн ширээ нь дээрх химийн аюултай хорт бодисын зургийг доош харуулан байршуулсан байна./ Шүүгч 1-7 хүртэлх тооноос сугалаагаар багийн 1 гишүүнийг сонгоно.
 - Гурван зурган тэмдэглэгээг зөв тааж чадвал 3 минут
 - Хоёр зурган тэмдэглэгээг зөв тааж чадвал 2 минут
 - Нэг зурган тэмдэглэгээг зөв тааж чадвал 1 минутын шагнал тус тус өгнө.
- Тэмцээн зохион байгуулагч тал амьсгал хамгаалах багийг цэг дээр бэлэн байлгах асуудлыг хариуцана.

Зургаадугаар цэг: Гал унтраах

- Бүлгийн гишүүд тавдугаар цэгээс гарч 150м замыг туулан зургаадугаар цэгт ирнэ.
- Багийн бүх гишүүд зориулалтын гал унтраах багаж /РЛО/-г үүрэн 20м замыг туулж саадыг тойрон, галын дөлний хэлбэрт байг РЛО ус шүршигч ашиглан 2 минутын хугацаанд унагана. Унагасан бай бүрийн тоогоор 1 минутын шагнал өгнө. /Хавсралт2/
- Бүлэг зургаадугаар цэгээс зам дахь саадыг давж, 50 митр замыг туулан барианд орно.

Ерөнхий зүйл:

Цагчин шүүгч бүлгийг гараанаас гарч, барианд орсон сүүлчийн хүнээр тооцож цэвэр цагийг гаргана.

Тэмцээнийг маргаангүй болгох үүднээс эхний бүлгийг барианд орсноос хойш дараагийн бүлгийг гараанаас гаргана.

Тухайн цэг дээр бүлгийн гүйцэтгэх үүрэгтэй нь уялдуулан цэгийн шүүгчээр мэргэжлийн хүнийг ажиллуулах бөгөөд шүүгч бүлгийн авсан үнэлгээг цэг дээр нь танилцуулж ерөнхий шүүгчид гар станцаар тухай бүр оноог мэдээллэнэ.

Гараа бариан дээр ерөнхий шүүгч багийн жагсаалт, цэгийн тэмдэглэгээ бүхий самбар дээр оноог ил, нээлттэй хөтлөн явуулна.

Тэмцээнийг 400-800 метрийн гүйлтийн талбай буюу түүнтэй адилтгах газар байршилд зохион байгуулна.

Оролцогч хүүхдүүдийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангаж, гарааны цэгт аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч, эмнэлгийн яаралтай тусламжийн баг ажиллана.

Дугуй болон торон саад, дүүжин савлуур, самбар зэрэг төхөөрөмжийн дэргэд дундын хянагчийг ажиллуулж бүлгийн гишүүдийн гаргасан алдааг тухай бүр нь засуулан, тэдний аюулгүй байдлыг ханган ажиллана.

Долоо. Дүгнэх журам

Дүнг гаргахдаа нийт хугацаанаас (цэвэр цаг) шагналын минутыг хасч, торгуулийн минутыг нэмж хамгийн бага цагаас эхлэн байр эзлүүлнэ.

Оноо тэнцсэн нөхцөлд багийн ахлагч нарын дунд асуулт, хариултын тэмцээн зохион явуулна.

Найм: Шагнал урамшуулал

Тэмцээнд оролцсон багуудыг онооны дарааллаар 1, 2, 3, тусгай байр эзлүүлж, шагнаж урамшуулна.

1 дүгээр байр: Цом, алтан медаль, 650.000 төгрөг, дурсгалын зүйлс

2 дугаар байр: Мөнгөн медаль, 550.000 төгрөг, дурсгалын зүйлс

3 дугаар байр: Хүрэл медаль, 450.000 төгрөг, дурсгалын зүйлс

4 “Өсвөрийн аврагч” тэмцээний шагнал урамшууллыг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс шийдвэрлэх ба хамтран оролцох байгууллагууд болон энэхүү удирдамжид нийцүүлэн зохион байгуулна.

Ес:Шүүгчдийн бүрэлдэхүүнд:

- Онцгой байдлын газар
- Аймгийн Засаг даргын тамгын газар
- Улаан загалмайн дунд шатны хороо
- Боловсрол шинжлэх ухааны газар
- Гэр, бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар

ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗАР

Булган аймгийн Засаг даргын
2023 оны 06 дугаар сарын 07-ийн
өдрийн 1/469 дүгээр захирамжийн хоёрдугаар хавсралт

АЙМГИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ "ӨСВӨРИЙН АВРАГЧ-2023" ТЭМЦЭЭНД
ЗАРЦУУЛАГДАХ ХӨРӨНГИЙН ТӨСӨВ

Д/д	Хэрэглэгдэхүүн	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ	Тайлбар
1	1-р байр мөнгөн шагнал	1	650000	650000	Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгө
2	2-р байр мөнгөн шагнал	1	550000	550000	Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгө
3	3-р байр мөнгөн шагнал	1	450000	450000	Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгө
4	медаль	24	12000	288000	Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгө
5	Цом	1	50000	50000	Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгө
6	Өргөмжлөл	3	15000	45000	Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгө
7	Баннар	1	3x4x19500	162000	Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгө
Нийт дүн				2195000 төг	

___оОо___